



Олон улсын түнш байгууллага хууль тогтоомжийг дагаж мөрдөх тухай бодлого

1-р хувилбар (албан бус орчуулга)
2016

Олон улсын түнш байгууллага хууль тогтоомжийг дагаж мөрдөх тухай бодлого

Бодлогын зорилго. MoneyGram компанийн агент,¹ агентын бус, түгээх сувгууд бол² MoneyGram компанийн мөнгө шилжүүлэх, бусад үйлчилгээ, бүтээгдэхүүнийг манай эрхэм үйлчлүүлэгчдэд хүргэдэг чухал түнш юм. MoneyGram компани, түүний түнш байгууллага дэлхий даяар янз бүрийн хууль, Засгийн газрын дүрэм журмыг дагаж мөрдөх шаардлагатай байдаг тул MoneyGram компани энэ *Олон улсын түнш байгууллага хууль тогтоомжийг дагаж мөрдөх тухай бодлогыг* ("Бодлого") гаргасан юм.

Агентууд, тэдгээрийн ажилтнууд үйлчлүүлэгчдийг хамгаалж, MoneyGram компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг буруугаар ашиглаж залилахаас урьдчилан сэргийлэх тэргүүн эгнээнд ажилладаг. Тус бодлого олон улс даяарх агентуудын холбогдох хууль тогтоомж, MoneyGram компанийн бодлого, журмыг дагаж мөрдөх үүрэг, мөн мөнгө угаах, залилантай тэмцэх нарийн чанд тогтсон хэм хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах үйл ажиллагааг тусган харуулна.

Энэ бодлого үйлчлүүлэгчдийг хамгаалж, залилан мэхлэх зорилгоор, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эсвэл бусад хууль бус үйл ажиллагаанд аливаа этгээд бүтээгдэхүүн, үйлчилгээг нь ашиглахаас сэргийлэх MoneyGram компанийн үүрэг амлалтыг мөн батжуулна. MoneyGram компани өөрийн агент, тэдгээрийн эзэд, хувь нийлүүлэгчид, удирдах эрх бүхий байгууллага, удирдлага, ажилтнуудаас ижил үүрэг амлалт авахыг шаарддаг. Агентууд энэ бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэй. Энэхүү бодлогыг хэрэгжүүлэхийн тулд MoneyGram компани MoneyGram, түүний агент хоорондын харилцааг зохицуулдаг үндсэн шаардлагыг энд тусгасан.

MoneyGram компани энэ бодлогыг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудалтай танилцаж, арга хэмжээ авахын тулд Мөнгө угаах, залилантай тэмцэх хууль тогтоомжийг дагаж мөрдөх хөтөлбөрөөр ("Хөтөлбөр") шинэчилсээр байна. MoneyGram компанийн бүсийн хууль тогтоомж хариуцсан ажилтан эсвэл энэ бодлоготой холбоотой асуултын талаар тухайн агентад оноосон бусад хууль тогтоомж хариуцсан ажилтантай холбоо барихыг MoneyGram зөвлөж байна.

1 ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ ЁСЗҮЙТЭЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ

Агент, тэдгээрийн ажилтнуудын үндсэн үүрэг хууль тогтоомжийн дагуу ёсзүйтэй үйл ажиллагаа явуулахад оршино. Үүнд аливаа агент холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг бүрэн дагаж мөрдөөд зогсохгүй мөн MoneyGram компанийн хамтран ажилладаг байгууллагууд MoneyGram компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлчлүүлэгчдэд санал

¹ Агент гэсэн тодорхойлолтод MoneyGram компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлчлүүлэгчдэд үзүүлэх зорилгоор MoneyGram компани эсвэл түүний салбар нэгжтэй гэрээний харилцаа тогтоосон аливаа этгээд багтана. Энэ тодорхойлолтод бас агентын бүх дэд агент багтана.

² MoneyGram компани итгэмжлэгч/агентын харилцаанаас өөр арга хэлбэрээр зарим нэг бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлдэг. MoneyGram компани эдгээр түгээх сувгийг хянадаггүй. Санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээний ялгаа эсвэл эдгээр түгээлтийн сувагт хамаарах зохицуулалтын шаардлагын ялгааг харгалзан үзвэл агентын бус, түгээх сувгийн үүрэг өөр өөр байж болох бөгөөд MoneyGram компани тэдэнтэй байгуулах гэрээнд энэ тухай нарийвчлан тусгах болно.

болгодог тул үнэнч шударга ажиллах болно гэсэн шаардлага багтана. Агент, тэдгээрийн ажилтнуудын нэр хүнд MoneyGram компанийн нэр хүндэд шууд нөлөөлдөг. Тиймээс MoneyGram компани агент, тэдгээрийн ажилтнуудын зан байдлыг зохицуулсан журмыг доор толилууллаа.

1.1 Агент, тэдгээрийн ажилтнууд үйл ажиллагаа явуулж буй бүх улсад холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг даган мөрдөж ажиллана.

- Улс, муж улс/орон нутгийн эсвэл орон нутгийн хууль тогтоомж эсвэл дүрэм журмаар шаарддаг аливаа шаардлагатай бүртгэл эсвэл тусгай зөвшөөрлийг авч, сунгаж, байрлуулна.
- Агент, тэдгээрийн ажилтнууд залилан, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эсвэл бусад хууль бус үйл ажиллагаанд оролцож эсвэл санаатай туслалцаа дэмжлэг үзүүлж болохгүй.
- Агент сэжигтэй байж болзошгүй байршил, ажилтны үйлдэл, мөн аливаа ажилтан эсвэл байршил шийдвэрлээгүй хэт олон гүйлгээний зөрчил эсвэл сэжигтэй байж болзошгүй гүйлгээ хийх эсвэл мөрдөж шалгах шаардлагатай хэвийн бус зан байдал гаргах тохиолдлыг хянаж ажиглана. Хэрэв аливаа байршил эсвэл ажилтныг хууль бус үйл ажиллагаанд хамтран оролцсон эсхүл оролцсон гэж сэжиглэж байгаа бол агент энэ бодлогод заасны дагуу арга хэмжээ авна.

1.2 Агент, тэдгээрийн ажилтнууд үнэнч шударга байж, маргашгүй ёсзүйн хэм хэмжээг мөрдөж баримтална.

- Агент, тэдгээрийн ажилтнууд MoneyGram компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлэхдээ харилцдаг хүмүүстэй үнэнч шударга ажиллана. Агент, тэдгээрийн ажилтнууд MoneyGram компанийн нэр хүндийг үйлчлүүлэгч, нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч, өрсөлдөгч, төрийн албан хаагчдын дунд гутааж болох үйлдэл хийхгүй.
- Хэрэв тухайн гүйлгээг ямар нэгэн хууль бус үйл ажиллагаатай холбоотой гэж сэжиглэж байгаа бол агент, тэдгээрийн ажилтан үүнийг хийхгүй. MoneyGram компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зөвхөн хуульд заасан зориулалтаар ашиглавал зохино.
- Агент, тэдгээрийн ажилтнууд энэ бодлогыг зөрчиж, MoneyGram компани, үйлчлүүлэгч, хууль сахиулах эсвэл зохицуулалтын байгууллагад худал эсвэл төөрөгдүүлсэн мэдээлэл өгч болохгүй.

1.3 Агент энэ хэсгийг зөрчихийг таслан зогсоож, холбогдох этгээдэд асуудлыг мэдээлэх арга хэмжээ авна.

- Хэрэв агент эсвэл түүний ажилтан аливаа агент эсвэл ажилтан тус Бодлогын энэ хэсгийг зөрчсөн гэж үзэхэд хүргэх мэдээллийн талаар олж мэдвэл тухайн агентад оноосон MoneyGram компанийн Бүсийн хууль тогтоомжийн хэрэгжилт хариуцсан ажилтан, MoneyGram компанийн хууль тогтоомжийн хэрэгжилт хариуцсан Ерөнхий захирал эсвэл MoneyGram компанийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг мэдээлэх шууд утсанд энэ мэдээллийг өгнө. (Холбоо барих чухал мэдээллийг үзнэ үү.)
 - Хэрэв агент эсвэл түүний ажилтан аливаа агент эсвэл ажилтан ёсзүйгүй, зохисгүй эсвэл хууль бус үйлдэлд оролцсон эсвэл төрийн аливаа холбогдох хууль, дүрэм эсвэл журмыг зөрчсөн гэж үзэхэд хүргэх мэдээллийн талаар олж мэдвэл тухайн агентад оноосон MoneyGram компанийн Бүсийн хууль тогтоомжийн хэрэгжилт хариуцсан ажилтан, MoneyGram компанийн хууль тогтоомжийн хэрэгжилт хариуцсан Ерөнхий захирал эсвэл MoneyGram компанийн Хууль тогтоомжийн хэрэгжилтийг мэдээлэх шууд утсанд энэ мэдээллийг өгнө. (Холбоо барих чухал мэдээллийг үзнэ үү.)
 - Агент, тэдгээрийн ажилтнууд MoneyGram компанийн Хууль тогтоомжийн шууд утсыг ашиглан сэжигтэй зөрчлийг нэрээ хэлэхгүйгээр мэдээлж болно. MoneyGram компани тухайн мэдээллийг хууль эсвэл дүрэм журмын дагуу задруулах шаардлагагүй бол мэдээлэл өгсөн хүмүүсийн нууцыг хадгалахын тулд бүхий л хүчин чармайлт гаргана.
 - MoneyGram компани мэдэгдэл хийсэн, зөрчлийг мэдээлсэн эсвэл мөрдөн шалгах үеэр мэдээлэл өгсөн хэнд ч өс санаж, хариу авахыг ямар ч нөхцөл байдалд тэвчиж хүлцдэггүй. Хэрэв агент эсвэл түүний ажилтнаас хариу авсан гэж тэд үзэж байгаа эсвэл тэд хариу авсан тохиолдлын талаар мэдэж байвал тухайн хариу авсан тохиолдлыг тус агентад оноосон MoneyGram компанийн Бүсийн хууль тогтоомжийн хэрэгжилт хариуцсан ажилтан, MoneyGram компанийн хууль тогтоомжийн хэрэгжилт хариуцсан Ерөнхий захирал эсвэл MoneyGram компанийн Хууль тогтоомжийн хэрэгжилтийг мэдээлэх шууд утсанд нэн даруй мэдэгдэнэ.
- 1.4 Агент, тэдгээрийн ажилтнууд холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээллийг MoneyGram компани, хууль сахиулах эсвэл зохицуулалтын эрх бүхий байгууллагад өгнө. Үүнд дараах нөхцөл байдал багтана.
- MoneyGram компанийн системд мэдээлэл оруулах, MoneyGram компанийн ажилтанд биеэр эсвэл агент хөтөлбөрийн үнэлгээний үеэр мэдээлэл өгөх үед;
 - MoneyGram компани гүйлгээ эсвэл мөнгө угаах, залилантай тэмцэх хөтөлбөрийн талаар мэдээлэл өгөхийг хүссэн үед;

- Өргөдөл гаргах процесс, гэрээ сунгах, агентын сэргээсэн файлыг шалгах эсвэл хууль тогтоомжийн шаардлагыг хангах зорилготой магадлан шинжилгээ, хууль тогтоомжийн биелэлтийн үнэлгээ эсвэл MoneyGram компани үндэслэлтэй хүсэлт тавьсан үед;
- Тухайн агентын өмчлөл эсвэл дээд удирдлагад өөрчлөлт гарсан үед;
- хууль сахиулах эсвэл иргэний зохицуулалтын байгууллага хууль ёсоор хүсэлт тавьсан үед.

2 ХЭЭЛ ХАХУУЛЬ, АВИЛГЫГ ХОРИГЛОХ

Шударга бус бизнесийн давуу тал олж авахын тулд зохисгүй төлбөр төлөх эсвэл зохисгүй бэлэг эсвэл шан хөлс өгөхийг дэлхий даяар янз бүрийн хууль тогтоомжийн дагуу хориглодог. Америкийн Нэгдсэн Улсад төвтэй компанийн хувьд MoneyGram Гадаад улс орон дахь авилгын тухай хууль (ГУОДАТХ), холбооны болон муж улсын худалдаа арилжааны хээл хахуулийн тухай хууль тогтоомж, мөн Нэгдсэн Вант Улсын Хээл хахуулийн тухай хууль ("НВУХХТХ") гэх зэрэг MoneyGram компани үйл ажиллагаа явуулдаг янз бүрийн улс орнуудын авилгатай тэмцэх, худалдаа арилжааны хээл хахуулийн тухай хуулийг дагаж мөрддөг. MoneyGram компани бизнесийн ажил хэргийг ямар ч өө сэвгүй явуулж, холбогдох авилгатай тэмцэх хууль тогтоомж, ялангуяа Гадаад улс орон дахь авилгын тухай хууль, Нэгдсэн Вант Улсын Хээл хахуулийн тухай хуулийг дагаж мөрдөхийг өөрийн агент, тэдгээрийн ажилтнуудаас шаарддаг.

2.1 Агент, тэдгээрийн ажилтнууд MoneyGram компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгох, MoneyGram компанийн үйл ажиллагаатай холбогдуулан зүй бус давуу байдлыг олж авахын тулд хээл хахууль эсвэл авилга өгч авахгүй. Энэхүү хориг төрийн албан хаагчид эсвэл худалдаа арилжааны этгээдтэй хийх аливаа гүйлгээнд хамаарна.

"Төрийн албан хаагч" гэсэн нэр томъёонд дараах этгээд багтана.

- Сонгогдсон, мэргэжлийн ажилтан эсвэл улс төрийн томилгоо эсэхээс үл хамааран засгийн газрын (улс, муж улс эсвэл аймаг, бүс нутаг эсвэл орон нутгийн) аль ч түвшинд аливаа төрийн байгууллагын хэлтэс, агентлаг, комисс, товчоо, эсхүл эрх бүхий байгууллагын албан хаагч, ажилтан;
- Хууль тогтоогч, шүүгч;
- Төрийн хэвшлийн байгууллагыг төлөөлөн албан ёсны үүрэг гүйцэтгэж буй аливаа этгээд;
- Төрийн хэвшлийн байгууллагын эзэмшдэг эсвэл хянадаг байгууллагын албан хаагч, ажилтан;
- Улс төрийн албан тушаалд нэр дэвшигч;

- Улс төрийн намын албан хаагч, ажилтан;
- Төрийн хэвшлийн олон улсын байгууллагын албан хаагч, ажилтан;
- MoneyGram компани үйл ажиллагаа явуулдаг улс орны хуулийн дагуу төрийн албан хаагч гэж үздэг аливаа этгээд.

“Арилжааны тал” гэж ажилтан нь “төрийн албан хаагч” гэсэн шалгуурыг хангахгүй аливаа компани, байгууллага эсвэл аж ахуйн этгээд, мөн аливаа ажилтан, төлөөлөгч, итгэмжлэгдсэн этгээд эсвэл тухайн талын захиран зарцуулах эрхтэй этгээдийг хэлнэ.

- 2.2 Агент Бодлогын энэ хэсэг, холбогдох хээл хахууль, авилгатай тэмцэх хууль тогтоомжийг зөрчиж болзошгүй тохиолдлоос сэргийлэх, хориглох, илрүүлэхийн тулд зохих хяналтын арга хэмжээ авна.

3 МӨНГӨ УГААХ, ЗАЛИЛАНТАЙ ТЭМЦЭХ ҮР ДҮНТЭЙ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ

Агентууд гэмт хэргийн үйл ажиллагаанд MoneyGram компанийн бүтээгдэхүүн, систем, мөн нийт санхүүгийн тогтолцоог ашиглахаас урьдчилан сэргийлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Үүний тулд MoneyGram компани энэ бодлогыг даган мөрдөж, мөнгө угаах, залилантай тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхийг агентуудаасаа шаарддаг. Гэсэн хэдий ч агентууд энэ бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлнэ. MoneyGram компани агентуудад сургалт зохион байгуулах, мөнгө угаах, залилантай тэмцэх хөтөлбөрийг баримтжуулж хэрэгжүүлэхэд тэдэнд туслах материал зэрэг мэдлэг ойлголт өгөх зориулалттай материалаар хангах гэх мэт янз бүрийн арга хэлбэрээр агентууддаа дэмжлэг туслалцаа үзүүлдэг. Үүнээс гадна MoneyGram компани элсүүлэх үед болон тогтмол үнэлгээ хийх замаар агентын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хөтөлбөрийн үр дүнг хангахад тусалдаг. Агентууд доор заасан үүргийг биелүүлэх явцад MoneyGram компани тэдэнтэй ил тод харилцахыг эрмэлздэг.

- 3.1 MoneyGram компани үйлчлүүлэгчийг залилахаас сэргийлэхэд тусалж, мөнгө угаахтай тэмцэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх эсвэл бусад зохицуулалтын шаардлагыг хангахад хангалттай, бичгээр үйлдсэн, үр дүнтэй, эрсдэлд суурилсан бодлого журам, хөтөлбөрийг хэрэгжүүлж мөрдөнө.

- Доор тайлбарласан гүйлгээг хянаж, мэдээлэх системийг нэвтрүүлэн хэрэгжүүлэх ажиллагаанд харуулснаар агент үйл ажиллагаагаа эрсдэлд суурилсан арга барилаар явуулж, тухайн агентын газарзүйн байршлаас шалтгаалан гарах мөнгө угаах, залилах эрсдэл, агентаар үйлчлүүлдэг үйлчлүүлэгч, агент санал болгодог бүтээгдэхүүний талаар ойлголттой байвал зохино.

- Наад зах нь дараах шаардлагыг хангасан бөгөөд агентын үйл ажиллагааны эрсдэлд суурилсан мөнгө угаах, залилантай тэмцэх хөтөлбөрийг нэвтрүүлэн хэрэгжүүлнэ.
 - Хууль тогтоомжийн хэрэгжилт хариуцсан ажилтан томилох, ажилтны сургалт зохион байгуулах, гүйлгээг хянаж мэдээлэх, үйлчлүүлэгчийн мэдээллийг цуглуулж хадгалах, хэрэв шаардлагатай бол агентын мөнгө угаах, залилантай тэмцэх хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийлгэх. Эдгээр шаардлагыг доор илүү дэлгэрэнгүй тусгасан болно.
 - Агентын эзэн, удирдлагаас зөвшөөрөл, энэ бодлого, агентын мөнгө угаах, залилантай тэмцэх хөтөлбөрийг дэмжиж, дагаж мөрдөх амлалтыг авах;
 - Тэдний байранд хийсэн болон хийхээр завдсан гүйлгээнд хяналт тавих үр дүнтэй хөтөлбөр хэрэгжүүлж, холбогдох хууль тогтоомжийн дагуу холбогдох эрх бүхий байгууллагад сэжигтэй үйл ажиллагааг мэдээлж эсвэл MoneyGram компанид мэдээллийг илгээх. MoneyGram компанид мэдэгдэх ёстой нөхцөл байдлын зарим жишээг харуулъя.
 - Сэжигтэй үйл ажиллагаа сүлжээнээс нь ангид эсвэл гадна явагдаж байх магадлалтай, мөн сүлжээнээс нь гадна MoneyGram компанийн өөр бусад агентын байранд нөлөөлж болзошгүй гэж агент үзэх (хэрэв хамааралтай бол);
 - Агент хил дамнуулан шилжүүлэх талаар санаа зовж, гадаад улсын хууль сахиулах байгууллагад мэдэгдэх хэрэгтэй гэж үзэх;
 - Сэжигтэй эсвэл хэвийн бус шинэ хэв маяг эсвэл чиг хандлага хэмээн үзсэн зүйлийг агент илрүүлэх эсвэл;
 - Тухайн гүйлгээ терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болзошгүй гэж агент үзэх. Хэрэв тийм бол агент MoneyGram компани, хууль сахиулах байгууллагатай нэн даруй холбоо баривал зохино.
 - Хэрэв агент сэжигтэй үйл ажиллагааг MoneyGram компаниас шууд мэдээлэхийг шаарддаг улсад байвал хяналт ажиглалтын үр дүн, аливаа холбогдох мэдээллийг агент MoneyGram компанид зохих хугацааны дотор эсвэл холбогдох аливаа хууль эсвэл журмын дагуу өгөх ёстой.
 - Хууль тогтоомж эсвэл зохицуулалтын тайлагнах шаардлагыг биелүүлэхээс зайлсхийхийн тулд гүйлгээг нүүж далдлах, биеийн байцаалтын шаардлагыг биелүүлэхээс зайлсхийх, биеийн байцаалтын баримт бичгийг хамтран ашиглах, нэг хүн олон улс оронд хэт олон хүмүүст илгээх гэх зэрэг өөр бусад хэвийн бус үйлдэл гэх мэт сэжигтэй

эсвэл хэвийн бус байж болох үйл ажиллагаа гүйлгээнд байгаа эсэхийг хянаж ажиглах;

- Мөнгө угаах, залилантай тэмцэх үйл ажиллагааны үр дүнг баримтжуулж, холбогдох зохицуулалтын байгууллагад сэжигтэй үйл ажиллагааны тухай мэдээг өгөх эсвэл MoneyGram компанид сэжиг бүхий үйл ажиллагааг мэдэгдэх;
- Залилангийн үүдэлтэй, нүүн далдалсан эсвэл мөнгөний хууль бус шилжүүлэг эсвэл гүйлгээг илрүүлж сэргийлэхэд баримтлах бичгээр үйлдсэн бодлого журмыг ажилтнуудад өгөх;
- Сэжигтэй байж болзошгүй үйл ажиллагаа эсвэл их дүнтэй валютын гүйлгээний талаар мэдээлэхдээ баримтлах бичгээр үйлдсэн бодлого журмыг ажилтнуудад өгч, агентын үйл ажиллагаа явуулж буй улс оронд мөрддөг зохицуулалтын байгууллагын бусад шаардлагыг биелүүлэх. Эдгээр бодлого журамд сэжиг бүхий үйл ажиллагааны тухай мэдээлсэн үед үйлчлүүлэгчид “нууцаар мэдэгдэхийг хориглохтой” холбоотой үүргийг тусгавал зохино.
- Шаардлагатай үед сэжигтэй байж болзошгүй үйл ажиллагааг MoneyGram компанид хэрхэн мэдэгдэх талаар ажилтнуудад зааварчилгаа өгөх.
- Америкийн Нэгдсэн Улс дахь агентууд, Америкийн Нэгдсэн Улсаас өөр улс дахь арав эсвэл түүнээс олон салбартай агентуудын мөнгө угаах, залилантай тэмцэх хөтөлбөрийн үр дүнг үнэлэх хөндлөнгийн, эрсдэлд суурилсан үнэлгээ хийнэ. (“хөндлөнгийн үнэлгээ”) Эдгээр хөндлөнгийн үнэлгээг үе үе эсвэл холбогдох хууль тогтоомж, дүрэм журам эсвэл MoneyGram компаниас шаардсан давтамжтай хийнэ. Хөндлөнгийн үнэлгээг бичгээр баримтжуулж, хөндлөнгийн үнэлгээгээр илрүүлсэн аливаа зөрчлийн мөрөөр авсан арга хэмжээг агент баримтжуулна. Хөндлөнгийн үнэлгээнд тухайн агентын дараах үйл ажиллагааг харгалзаж үзнэ.
 - бичгээр үйлдсэн мөнгө угаах, залилантай тэмцэх хөтөлбөр;
 - агентын хууль тогтоомжийн хэрэгжилт хариуцсан ажилтны эрх мэдэл, мэдлэг туршлага;
 - ажилтны сургалт;
 - гүйлгээг хянаж, мэдээлэх ажиллагаа, шаардлагатай үед сэжигтэй үйл ажиллагааны мэдээг өгөх эсвэл MoneyGram компанид сэжигтэй үйл ажиллагааг мэдээлэх;

- энэ бодлогыг хэрэгжүүлж, баримтлахтай холбоотой өөр бусад зөрчил дутагдал.
- Агентын мөнгө угаах, залилантай тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлж баримтлах асуудлыг хариуцсан ажилтныг агент томилно. Энэ хууль тогтоомжийн хэрэгжилт хариуцсан ажилтан наад зах нь дараах шаардлагыг хангасан байх ёстой.
 - энэ бодлого, агентын мөнгө угаах, залилантай тэмцэх хөтөлбөрийг дэмжиж баримтлах үүрэг хүлээх;
 - агентын мөнгө угаах, залилантай тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлж мөрдөх чадвартай байх;
 - хэрэв хамааралтай бол сүлжээ даяар агентын мөнгө угаах, залилантай тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх мэдэлтэй байх;
 - агентын эзэн, удирдлагын дэмжлэгийг авч, эзэн эсвэл удирдлагатай шууд харилцах эрхтэй ажилтан эсвэл менежер гэсэн албан тушаалтай байх;
 - хэрэв хамааралтай бол агентын мөнгө угаах, залилантай тэмцэх хөтөлбөрт эрсдэлд суурилсан, хөндлөнгийн үнэлгээ хийлгэх эрхтэй байх;
 - агентын өдөр тутмын үйл ажиллагаа, MoneyGram компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар мэдлэгтэй байх.
- Агент энэ бодлого, мөн өөрийн баталсан бодлого журам, хөтөлбөрийг зохистой хэрэгжүүлэхэд хангалттай хөрөнгө нөөц, ажилтантай байна.
- Агент энэ бодлогод заасан ажил үүргийг шилжүүлэх эсвэл хуваарилах асуудлыг бичгээр тодорхой тусгаж, дэд агент хүлээн зөвшөөрсөн байна. (Зөвхөн Америкийн Нэгдсэн Улсаас өөр улс дахь тодорхой агентын харилцаанд хамааралтай.) Ажил үүргийг шилжүүлэх эсвэл хуваарилах асуудлыг үл харгалзан агент өөрийнх нь харьяанд ажиллаж буй дэд агентаас энэ бодлогын шаардлагыг биелүүлэхийг шаардана.

4 АГЕНТ, АЖИЛТНЫ СУРГАЛТ

Дээр дурдсанчлан агент, тэдгээрийн ажилтнууд үйлчлүүлэгчдийг хамгаалж, MoneyGram компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг буруугаар ашиглаж залилахаас урьдчилан сэргийлэх тэргүүн эгнээнд ажилладаг. MoneyGram компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг ашиглах явцад алдаа эсвэл гажуудал гарахаас сэргийлэхэд шаардлагатай сургалтыг агент,

ажилтнуудад зохион байгуулж, тэднийг зохих арга хэрэгслээр хангах ёстой. Үүнээс гадна ажилтны сургалтын хүрээнд агентын удирдлага холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг дагаж мөрдөхийг бүрэн дэмждэг болохыг агент ажилтнууддаа хэлж мэдээлбэл зохино. MoneyGram компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлчлүүлэгчдэд үзүүлэхийг зөвхөн зохих ёсоор бэлтгэгдсэн ажилтанд зөвшөөрөхийг MoneyGram компани агентаас шаарддаг.

4.1 Агент MoneyGram компанийн системийг ашиглан гүйлгээ хийхийг ажилтнуудад хангалттай зааж сургаж, энэ бодлого, агентын мөнгө угаах, залилантай тэмцэх хөтөлбөрийг дагаж мөрдөхийг шаардана. MoneyGram компани бодлого журам, хөтөлбөрөө байнга сайжруулдаг бөгөөд хууль тогтоомж, дүрэм журам, салбарын шилдэг арга ажиллагаанд гарсан өөрчлөлт эсвэл эрсдэлд тулгуурлан агентын үүрэг хариуцлагыг хэдийд ч өөрчилж болно. Агент тэдгээр өөрчлөлтийн талаар өөрийн ажилтан, аливаа дэд агентад (Зөвхөн Америкийн Нэгдсэн Улсаас өөр улс дахь тодорхой агентын харилцаанд хамааралтай.) мэдээлж мөрдүүлэх үүрэгтэй.

4.2 Агент MoneyGram компанийн зохион байгуулсан сургалт эсвэл үүнтэй ижил төстэй сургалтыг ашиглан MoneyGram компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг ашиглан үйлчлүүлэгчидтэй харилцдаг бүх ажилтанд мөнгө угаах, залилантай тэмцэх арга хэмжээг зааж сургана. Энэ сургалтыг доод тал нь хоёр жил тутам эсвэл тухайн улсын хууль тогтоомж эсвэл дүрэм журам эсвэл MoneyGram компаниас шаардсанаар олон удаа зохион байгуулна. Энэ сургалтад дараах зүйлийг тусгана.

- энэ бодлогод заасан бүх шаардлагыг дагаж мөрдөх;
- үйлчлүүлэгчийг мэхлэх үйлдэл, залилангийн сэдэлтэй шилжүүлгийг илрүүлэх;
- үйлчлүүлэгчийн биеийн байцаалтыг шалгах;
- гүйлгээ хийхэд тавьдаг холбогдох бүх шаардлага, өгөгдлийг зөв цуглуулж оруулах журмыг дагаж мөрдөх;
- сэжигтэй үйл ажиллагаа, нуун далдалсан гүйлгээг илрүүлж мэдээлэх;
- бүртгэл мэдээллийг хадгалах шаардлагыг хангах.

4.3 Агент ажилтнууддаа үүрэг хариуцлагыг нь ойлгуулж, шаардлагатай бол тэднийг давтан сургалтад хамруулах үүрэгтэй. Мөн энэ бодлого эсвэл агентын мөнгө угаах, залилантай тэмцэх бодлого эсвэл журмыг дагаж мөрдөхтэй холбоотой ажлын гүйцэтгэлийн асуудал илрэх тохиолдолд агент ажилтны нэмэлт сургалт зохион байгуулна. Ажилтнуудын дагаж мөрдөхтэй холбоотой

үүрэг хариуцлагыг батлан харуулахын тулд тэднээс мэдлэгийн шалгалт авбал зохино.

- 4.4 Агент сургалтын бүх сургалтын бүртгэл мэдээллийг баримтжуулж хөтөлнө. Эдгээр баримт бичгийг ажилтны хүвийн хэрэг эсвэл MoneyGram компанийн сургалтын удирдлагын системд хадгалж, хүсэлт тавьсны дагуу MoneyGram компани эсвэл зохих төрийн байгууллагад өгнө.

5 ХУУЛЬ САХИУЛАХ, ЗОХИЦУУЛАЛТЫН БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ

MoneyGram компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг ашиглан хууль бус үйл ажиллагаа явуулахыг оролддог хүмүүсийг баривчлан яллахад туслахын тулд MoneyGram компани дэлхий даяар хууль сахиулах байгууллагатай хамтран ажилладаг. Мөн олон улс оронд төрийн эрх бүхий байгууллага MoneyGram компани, түүний агентууд MoneyGram компанийн бодлого журам, хууль тогтоомж, дүрэм журмыг дагаж мөрддөг эсэхийг шалгах шалгалтад хамрагдана. Засгийн газрын зохицуулалтын байгууллага, хууль сахиулах агентлаг үе үе бүртгэл мэдээлэл өгөхийг хүсэж болно.

- 5.1 Үйлчлүүлэгчийн залилан эсвэл мөнгө угаахтай тэмцэхтэй холбоотой хууль тогтоомжийн асуудлаар холбоо барьсан үед агентууд MoneyGram компани, хууль сахиулах эсвэл зохицуулалтын байгууллагуудтай хуулиар зөвшөөрсөн дээд хэмжээнд бүрэн хамтран ажиллана. Хэрэв тухайн хүсэлтэд хариу өгөх боломжгүй бол агент туслалцаа дэмжлэг авахаар MoneyGram компанитай нэн даруй холбоо барина. (Холбоо барих чухал мэдээллийг үзнэ үү.)
- 5.2 Аливаа агенттай холбоотой эсвэл хамаатай бөгөөд зарлан дуудах хуудас, гэрчээр оролцохоор шүүхэд дуудах хуудас, шүүхийн шийдвэр эсвэл MoneyGram компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээ эсвэл үйл ажиллагаатай холбоотой албан ёсны аливаа лавлах хүсэлт хүлээн авсан аливаа этгээд MoneyGram компанитай нэн даруй холбоо барина. (Холбоо барих чухал мэдээллийг үзнэ үү.)
- 5.3 Агент, түүний ажилтан хамтран ажиллаж, мэдээлэл өгөхийг хүссэн хууль ёсны дараах бүх хүсэлтэд хурдан шуурхай хариу өгнө.
- Бүртгэл мэдээлэл эсвэл бусад мэдээлэл өгөхийг хүссэн MoneyGram компанийн аливаа хүсэлт;
 - Аливаа зохицуулалтын байгууллагын шалгалт, үзлэг, агентын үйл ажиллагааны хөндлөнгийн шинжилгээ эсвэл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээ;

- Бүртгэл мэдээлэл, зарлан дуудах хуудас, бүтээгдэхүүний захиалгыг өгөхийг хүссэн аливаа төрийн байгууллагын хүсэлт эсвэл MoneyGram компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг агент борлуулахтай холбоотой бусад хүсэлт.

6 ГҮЙЛГЭЭ, БҮРТГЭЛ ХӨТЛӨХӨД ТАВИХ ШААРДЛАГА

MoneyGram компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээний цөм нь бидний хийдэг гүйлгээ билээ. Агент, түүний ажилтнууд (хамааралтай үед) MoneyGram компанийн гүйлгээг зөв, хурдан шүүрхай хийхийн тулд бүрэн, үнэн зөв мэдээлэл цуглуулах шаардлагатай. Агент, түүний ажилтнууд (хамааралтай үед) гүйлгээ хийх процессын туршид үйлчлүүлэгчдээс (гүйлгээг биеэр ирж хийх тохиолдолд) янз бүрийн төрлийн мэдээлэл, зөвхөн баримтат мэдээлэл бус мөн дохио зангаа, дууны өнгө гэх мэт зан байдлын/хэл ярианы бус мэдээллийг цуглуулдаг. Цуглуулж ажигласан мэдээлэл MoneyGram компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хууль бус зорилгоор ашиглахаас сэргийлэхэд тус нэмэртэй байж болох бөгөөд мөнгө угаах, залилантай тэмцэж, сэжигтэй үйл ажиллагааг мэдээлэх үүргийг нь биелүүлэхэд MoneyGram компани, агентад тусалж болох юм. Мөн агентууд гүйлгээ, сэжигтэй үйл ажиллагаа, бусад зохицуулалтын тайлан мэдээтэй холбоотой бүртгэл мэдээллийг хадгалахыг зохицуулсан хууль тогтоомж, дүрэм журмыг дагаж мөрдөнө.

- 6.1 Америкийн Нэгдсэн Улсад байрладаг эсвэл Америкийн Нэгдсэн Улсад салбартай агентууд Банкны нууцын тухай хуулиар ("БНТХ") шаардсан бүх бүртгэл мэдээлэл, тайлагнах баримт бичгийг доод тал нь таван (5) жилийн (эсвэл муж улсын тодорхой хуулинд³ заасан бол илүү удаан) хугацаанд аюулгүй, хамгаалалттай газар хадгалж, АНУ-ын Сангийн яам эсвэл бусад төрийн албан тушаалтны төлөөлөгчдөд саадгүй гаргаж өгнө.
- 6.2 Америкийн Нэгдсэн Улсад байрладаг эсвэл Америкийн Нэгдсэн Улсад салбартай агентууд Мөнгө угаахтай тэмцэх ажлын хэсгийн ("МУТАХ") зөвлөсний дагуу мэдээлэл өгөх хүсэлтийг биелүүлэхийн тулд гүйлгээ, үйлчлүүлэгчийн шаардлагыг хангах зорилготой магадлан шинжилгээтэй холбоотой бүх мэдээллийг хадгална.
- 6.3 Үйлчлүүлэгчийн залилан, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх ажиллагааг хянаж ажиглах, сэргийлэх, мэдээлэх хүчин чармайлтыг нь баримтжуулсан бүртгэл мэдээллийг агентууд доод тал нь таван (5) жилийн (хэрэв тухайн улсын хууль тогтоомж эсвэл дүрэм журмаар шаардсан бол илүү удаан) хугацаанд хадгалах шаардлагатай.
- 6.4 Агент, түүний ажилтнууд гүйлгээг хийж дуусгахын өмнө илгээх маягт дээрх анхааруулга эсвэл бүтээгдэхүүний холбогдох бусад баглаа боодлыг харуулан

³ БНТХ-иас гадна Америкийн Нэгдсэн Улсад байрладаг эсвэл Америкийн Нэгдсэн Улсад салбартай агентууд Цахим хэлбэрээр мөнгө шилжүүлэх тухай хуулинд шаардсан бүх бүртгэл мэдээлэл, тайлагнах баримт бичиг, агентын баримт/хувийг доод тал нь хоёр (2) жилийн (эсвэл муж улсын тодорхой хуулинд заасан бол илүү удаан) хугацаанд аюулгүй, хамгаалалттай газар хадгална.

залилах зорилгоор хийж буй “луйврын” талаар үйлчлүүлэгчдэд анхааруулбал зохино.

6.5 Агент, түүний ажилтнууд дараах зүйлийг хийнэ.

- Хамааралтай үед үйлчлүүлэгчээр илгээх, хүлээн авах маягтыг бүрэн, үнэн зөв бөглүүлж, гарын үсэг зуруулах.
- Тухайн улсын шаардлага, MoneyGram компанийн бодлого журмын дагуу гүйлгээг хийхийн өмнө үйлчлүүлэгчийн хүчинтэй биеийн байцаалтыг авах.
- Өгөгдлийн чанарыг хангаж, гүйлгээг хийхэд гарах саатлыг бууруулахын тулд MoneyGram компанийн системд үйлчлүүлэгчийн биеийн байцаалтын мэдээллийг бүрэн, үнэн зөв оруулах.
- Холбогдох хууль тогтоомж эсвэл дүрэм журмаар шаардсаны дагуу хачирхалтай эсвэл мөнгө угаах ажиллагаатай холбоотой байж болзошгүй гүйлгээг холбогдох байгууллагад мэдэгдэж эсвэл MoneyGram компанид мэдэгдвэл зохино.
- Залилангийн сэдэлтэй гүйлгээнд оролцсон байж болох үйлчлүүлэгчдийг гүйлгээнийх нь талаар байцаах. Хэрэв тухайн гүйлгээ залилангийн сэдэлтэй гэсэн үндэслэл бүхий сэжиг байвал агент эсвэл түүний ажилтан гүйлгээг хийхээс татгалзаж, холбогдох хууль эсвэл журмаар шаардсан тохиолдолд энэ үйлдлийг MoneyGram компани, холбогдох байгууллагад аль болох хурдан мэдэгдэнэ.
- Залилангийн сэдэлтэй гүйлгээний хохирогч болсон хэмээн агент эсвэл түүний ажилтанд мэдэгдсэн үйлчлүүлэгчид залилангийн сэдэлтэй гүйлгээг MoneyGram компани эсвэл холбогдох байгууллагад тусад нь мэдэгдэх нь зүйтэй.

6.6 Үйлчлүүлэгчид мөнгийг олгохын өмнө агент, түүний ажилтан үйлчлүүлэгчээс лавлагаа дугаар өгөхийг хүсэж, энэ дугаарыг MoneyGram компанийн системд оруулна.

7 ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ

MoneyGram компани үйлчлүүлэгчдээ ёсзүйгүй, хууль бус үйлдлээс хамгаалахын төлөө ажилладаг. Хууль тогтоомж, дүрэм журмын дагуу авах боломжтой бүх арга хэмжээг ашиглан үйлчлүүлэгчид хохирох эрсдэлийг бууруулж, шударга бус, хуурамч эсвэл зүй бус үйлдэл эсвэл ажиллагаа эсвэл хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль тогтоомжийг зөрчих тохиолдлоос сэргийлэхийг MoneyGram компани агент, түүний ажилтнуудаас шаарддаг.

- 7.1 Агентууд гүйлгээ бүрд үйлчлүүлэгчээс авах хураамж төлбөртэй холбоотой, шаардлагатай бүх мэдээллийг үйлчлүүлэгчдэд өгнө.
- 7.2 MoneyGram компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг агентууд зөвхөн MoneyGram компанийн зөвшөөрч баталсан хэлээр үзүүлж болно.
- 7.3 Агентууд зөвхөн MoneyGram компанийн зөвшөөрч баталсан маркетингийн материалыг ашиглаж болно. Үүнд дотор, гадна байрлуулах тэмдэг тэмдэглэгээ, сурталчилгааны танилцуулга, тухайн улсын сонин сэтгүүлийн зар сурталчилгаа, лангууны үзүүлэн багтана.
- 7.4 Америкийн Нэгдсэн Улсын гүйвүүлгын дүрэм, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу шаардсан төлбөрийн өмнөх, төлбөрийн дараах мэдээллийн төрлийг үүсгэхээр MoneyGram компанийн системийг тусгайлан тохируулсан байдаг. Агентууд MoneyGram компанийн өгсөн эсвэл MoneyGram компанийн тоног төхөөрөмжөөс гаргасан төлбөрийн өмнөх, төлбөрийн дараах мэдээлэлд аливаа өөрчлөлт оруулж болохгүй.

8 ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН НУУЦЛАЛ, МЭДЭЭЛЛИЙГ ХАМГААЛАХ

MoneyGram компани аюулгүй, амар хялбар аргаар мөнгө илгээж, хүлээн авах боломж олгодог. MoneyGram компанийн үйлчлүүлэгчдийн өмнө хүлээсэн нэг үүрэг нь тэдний хувийн мэдээллийг хамгаалахад оршдог. Гүйлгээ хийх явцад агент, түүний ажилтнууд нэр, хаяг, утасны дугаар, төрийн байгууллагын үнэмлэх эсвэл татварын бүртгэлийн дугаар, паспортын дугаар, банкны дансны дугаар, кредит эсвэл дебит картын дугаар, төрсөн газар эсвэл огноо, ажил мэргэжил, эмэйл хаяг, мөн үйлчлүүлэгчийг магадлан шалгах өөр бусад мэдээллийг үйлчлүүлэгчдээс авч болно. Энэ мэдээллийг зөвшөөрөлгүй нэвтрэх, ашиглах, задруулахаас хамгаалахыг MoneyGram компани агент, түүний ажилтнуудаас шаарддаг.

- 8.1 Холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу зөвшөөрөлгүй нэвтрэх, ашиглах, задруулах сэргийлэхийн тулд агентууд үйлчлүүлэгчдийн хувийн мэдээллийг хамгаална.
- 8.2 Агентын мөнгө угаах, залилантай тэмцэх хөтөлбөрт нууцлал хамгаалах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах

журам багтана. Цуглуулж хадгалсан мэдээлэл, агентын бизнесийн үйл ажиллагааны төрөлтэй тохируулан эдгээр журмыг хэрэгжүүлнэ.

- 8.3 Агент, түүний ажилтнууд гүйлгээг зөвхөн хийхэд шаардлагатай мэдээллийг үйлчлүүлэгчдээс авна. Үйлчлүүлэгчдэд өгсөн баримт бичигт байгаа нөхцөл болзолд заасан тодорхойлж зөвшөөрсөн зорилгоор агент, түүний ажилтнууд үйлчлүүлэгчийн мэдээллийг зөвхөн ашиглана. MoneyGram компани өөрөөр зөвшөөрөөгүй бол үйлчлүүлэгчийн мэдээллийг зөвхөн (i) үйлчлүүлэгчийн гүйлгээг хийх, (ii) хууль тогтоомж/зохицуулалтын үүргийг биелүүлэх, (iii) мөнгө гуаах эсвэл залилангаас сэргийлэхийн тулд тус тус ашиглаж болно.
- 8.4 Агентууд зөвхөн холбогдох хүнд үйлчлүүлэгчийн мэдээллийг задруулж, зөвшөөрөлгүй аливаа гуравдагч этгээдэд хэрэглэгчийн мэдээллийг задруулахгүй.
- 8.5 Агентууд заасан зорилгыг биелүүлэхэд шаардагдах эсвэл хуулиар шаардсан хугацаагаар үйлчлүүлэгчийн хувийн мэдээллийг хадгална. Үйлчлүүлэгчийн хувийн мэдээллийг агуулсан бүх бичиг баримтыг найдвартай газар хадгална. Хэрэв агент гүйлгээг хянахад туслах хэрэгсэл ашигладаг бол мэдээллийн аюулгүй байдлын хангах зохих протоколыг дагах ёстой.
- 8.6 Агентууд хадгалах хугацааны эцэст үйлчлүүлэгчийн хувийн мэдээллийг зүй зохистой устгана.
- 8.7 Агент бусад ажилтантай хамтран ашигладаггүй хувийн таних дугаар, нууц үгийг ажилтан бүрд өгнө.
- 8.8 Агент, түүний ажилтнууд MoneyGram компанийн компьютер, програм хангамж, харилцаа холбооны хэрэгсэл, сүлжээний системийг хувийн зорилгоор ашиглах эсвэл MoneyGram компанийн үйл ажиллагаатай холбоогүйгээр ашиглахаас зайлсхийнэ. Эдгээр нь залилангийн гүйлгээ хийхэд хүргэж болзошгүй вирус эсвэл фишинг програм хангамжаар компьютер халдварлах хамгийн түгээмэл арга мөн учир агентууд зөвшөөрөлгүй нэвтрэхээс Мөнгө шилжүүлэх компьютерээ хамгаалж, интернетээр аялах, эмэйл илгээж хүлээн авах эсвэл шүүрхай зурвас (ШЗ) илгээж хүлээн авах зорилгоор ашиглаж болохгүй. Компьютерийн дэлгэц олон нийтэд харагдахгүй байвал зохино. Агентууд зохих вирусийн эсрэг програм хангамж, галт хана суулгаж, хамгаалалтын алдаа дутагдлыг засахын тулд автоматаар засвар, шинэчлэлийг татаж авахаар програм хангамжийг тохируулбал зохино.
- 8.9 Агент, үйлчлүүлэгч, MoneyGram компанид үзүүлж болзошгүй нөлөөллийг тодорхойлохын тулд үйлчлүүлэгчийн аливаа хувийн мэдээллийн нууцлал эсвэл хамгаалалтыг задруулсан, буруугаар ашигласан эсвэл зөрчсөн эсвэл

үүнд сэжиглэж буй аливаа тохиолдлыг нэн даруй агентын зохих удирдлага, MoneyGram компанид мэдэгдэнэ. (Холбоо барих чухал мэдээллийг үзнэ үү)

9 ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ТӨЛБӨРИЙГ БУЦААН ОЛГОХ

Гүйлгээг хийхэд хааяа алдаа гардаг. MoneyGram компани үйлчлүүлэгчид төлбөрийг буцаан олгох ёстой нөхцөл байдалд үйлчилдэг Америкийн Нэгдсэн Улсын гүйвүүлгын дүрэм, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг дагаж мөрдөх журам боловсруулсан. Гүйлгээний аливаа алдааг шийдвэрлэхийн тулд агентууд үйлчлүүлэгч, MoneyGram компанитай хамтран ажиллавал зохино. Мөн MoneyGram компани залилангийн сэдэлтэй гүйлгээг олгохоос сэргийлж, MoneyGram компанийн дүрэм журам, тухайн улсын хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль тогтоомжид нийцүүлэн төлбөрийг буцаан олгохын тулд бүх хүчин чармайлт гаргаж ажиллахыг агентуудаас шаарддаг.

- 9.1 Хэрэв илгээгч эсвэл хүлээн авагч алдаа гарсан гэж үзвэл MoneyGram компанитай нэн даруй холбоо барина уу. MoneyGram компани гарсан гэж үзэж буй алдааг шалгаж, үйлчлүүлэгчид төлбөрийг буцаан олгох эсэхийг шийдвэрлэнэ.
- 9.2 Үйлчлүүлэгчид төлбөрийг буцаан олгоход агент MoneyGram компанид туслалцаа үзүүлнэ.
- 9.3 Агент үйлчлүүлэгчид төлбөрийг буцаан олгох боломжгүй байсан ч гэсэн хэрэв үйлчлүүлэгч залилангийн сэдэлтэй төлбөр илгээсэн гэж үзэж байвал MoneyGram компанитай нэн даруй холбоо барихыг агент үйлчлүүлэгчид зөвлөнө.

10 ХЯНАЛТ, ЗАЛРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

MoneyGram компани агентууд хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хэр сайн гүйцэтгэдэг болохыг хянадаг. Үүнд агентын хийсэн гүйлгээг хянах үйл ажиллагаа багтана. Тухайн агент өөрийн бизнесийн загварт тохирсон хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үр дүнтэй хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлж, холбогдох хууль тогтоомж болон зохицуулалтын шаардлага, MoneyGram компанийн бодлого журам, гэрээний шаардлагыг хангаж буй эсэхийг үнэлэхийн тулд агентын мөнгө угаах, залилантай тэмцэх хөтөлбөр, Луйврын худалдаа, Газар дээрх шалгалт, хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах бусад хяналт шалгалтыг MoneyGram компани өөрийн үзэмжээр зохион байгуулдаг.

10.1 Хянах эсвэл залруулах арга хэмжээ авах хүргэж болзошгүй үйл ажиллагаа

- Энэ бодлого эсвэл холбогдох аливаа хууль эсвэл дүрэм журмыг зөрчсөн бүх агентад нэн даруй залруулах эсвэл засаж сайжруулах арга хэмжээ, туршилтын хугацаа өгөх, үйлчилгээг түдгэлзүүлэх эсвэл MoneyGram компанийн үйлчилгээг зогсоох арга хэмжээ авна.

- MoneyGram компани өөрийн үзэмжээр аливаа агентын үйл ажиллагаа үйлчлүүлэгч эсвэл MoneyGram компанийн нэр хүнд эсвэл системд зохисгүй эрсдэл учруулж байна гэж үзвэл MoneyGram компани залруулах эсвэл засаж сайжруулах арга хэмжээ, түршилтын хугацаа өгөх, үйлчилгээг түдгэлзүүлэх эсвэл MoneyGram компанийн үйлчилгээг арга хэмжээ авч болно. Залруулах эсвэл засаж сайжруулах арга хэмжээ авахад хүргэж болзошгүй үйл ажиллагаанд сэжигтэй эсвэл залилангийн сэдэлтэй гүйлгээ хийх үйлдэл багтана.
- Баримтжуулсан хөнгөлөх нөхцөл байдал байхгүй бол хууль бус гүйлгээний үйл ажиллагаанд тусалцаа үзүүлсэн эсвэл оролцсоныг нь тогтоосон аливаа агент MoneyGram компанийн үйлчилгээ үзүүлэхийг нэн даруй түдгэлзүүлж эсвэл зогсооно

10.2 Авч болзошгүй хянах, залруулах арга хэмжээ

- MoneyGram компани дээрх 10.1 хэсэгт заасан үйл ажиллагаатай холбогдуулан янз бүрийн залруулах эсвэл засан сайжруулах арга хэмжээ авахаар шийдэж болно. Эдгээр арга хэмжээнд дараах зүйл багтаж болно.
 - MoneyGram компанийн үйлчилгээг зогсоох;
 - MoneyGram компанийн мөнгө шилжүүлэх эсвэл бусад гүйлгээг хийх эрхийг түдгэлзүүлэх;
 - MoneyGram компанийн дараах үйлчилгээнд хязгаарлалт тавих (i) үйлчлүүлэгчийн биеийн байцаалттай холбоотой журмын шалгуурыг бууруулах; (ii) гүйлгээний хэмжээ эсвэл гүйлгээний дүнгийн хязгаарыг бууруулах; (iii) тодорхой дүнгээс дээш гүйлгээнд MoneyGram компаниас зөвшөөрөл авахыг шаардах; (iv) MoneyGram компани шаардлагатай гэж үзсэн бусад хориг арга хэмжээ;
 - MoneyGram компани агентын гүйлгээг нарийн хянаж шалгахын тулд агентад түршилтын хугацаа өгөх. Агентад түршилтын хугацаа өгөх тохиолдолд тухайн агентын хийх MoneyGram компанийн гүйлгээг 90 хоногийн хугацаанд эсвэл MoneyGram компани хангалттай гэж үзэх хүртэл хянаж ажиглана.
- Мөн MoneyGram компани дээрх 10.2 хэсэгт жагсааснаас тусдаа эсвэл тэдгээртэй хамтатган бусад залруулах арга хэмжээ авч болно. Эдгээр арга хэмжээнд дараах зүйл багтаж болно.
 - Илрүүлсэн асуудлын мөрөөр агентын авсан арга хэмжээтэй холбоотой тайлан хүлээн авахын тулд 30 хоног тутам агенттай холбоо барих;

- Агентаас баримт бичиг өгөхийг хүсэж, тэдгээртэй танилцах;
- Агенттай хамтран гүйлгээний дүн шинжилгээг 30 хоног тутам хийх.

10.3 Энэ бодлогыг зөрчих эсвэл хангалтгүй мөрдсөн тохиолдлыг шийдвэрлэхийн тулд агент MoneyGram компаниас шаардсан залруулах эсвэл засаж сайжруулах бүх арга хэмжээг зөвшөөрч хэрэгжүүлнэ. MoneyGram компаниас шаардсан залруулах эсвэл засаж сайжруулах арга хэмжээг зөвшөөрөөгүй эсвэл хэрэгжүүлээгүй агентын үйлчилгээг MoneyGram компани дуусгавар болгоно.

10.4 Шударга бусаар залруулах эсвэл засаж сайжруулах арга хэмжээ авсан хэмээн үзэж буй аливаа агент MoneyGram компанийн хууль тогтоомжийн хэрэгжилт хариуцсан Ерөнхий захиралтай дараах хаягаар холбоо барина.

MoneyGram International компани
Хэнд: Хууль тогтоомжийн хэрэгжилт хариуцсан Ерөнхий захирал
2828 Хойд Харвүүд гудамж, 15-р давхар
Даллас хот, Техас муж улс 75201 (+01) 214-999-7640

10.5 Агентын ажилтантай холбоотой залруулах арга хэмжээ

- Аливаа ажилтныг мөнгө угаах, үйлчлүүлэгчийг залилах эсвэл терроризмыг санхүүжүүлэх ажиллагаанд оролцсон хэмээн сэжиглэж буй тохиолдлыг шалгаж, зохих байгууллага, MoneyGram компанид мэдэгдэнэ.
- Мөнгө угаах, үйлчлүүлэгчийг залилах эсвэл терроризмыг санхүүжүүлэх ажиллагаанд оролцсон хэмээн сэжиглэж буй ажилтанд MoneyGram компанийн гүйлгээ хийхийг хориглож, MoneyGram компанийн системд тухайн ажилтан нэвтрэх эрхийг хаана.
- Хэрэв шалгасны дараа мөнгө угаах, үйлчлүүлэгчийг залилах эсвэл терроризмыг санхүүжүүлэх ажиллагаанд оролцсон хэмээн өмнө нь сэжиглэгдсэн ажилтан эдгээр үйл ажиллагаанд оролцоогүй гэж үзвэл агент тухайн ажилтны MoneyGram компанийн системд нэвтрэх эрхийг сэргээхийн өмнө MoneyGram компаниас зөвшөөрөл авна.

ХОЛБОО БАРИХ ЧУХАЛ МЭДЭЭЛЭЛ

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Хууль тогтоомжийн хэрэгжилт хариуцсан манай хэлтэстэй дараах хаягаар холбоо барьж болно.

MoneyGram International компани

Хэнд: Хууль тогтоомжийн хэрэгжилт хариуцсан Ерөнхий захирал

2828 Хойд Харвүүд гудамж, 15-р давхар

Даллас хот, Техас муж улс 75201 (+01) 214-999-7640

Холбоо барих шалтгаан	MoneyGram компанитай холбоо барих мэдээлэл
<p>Шууд утас Агент, түүний ажилтнууд залилангийн сэдэлтэй гүйлгээг зогсоох эсвэл утас эсвэл эмэйлээр нэрээ хэлэхгүй, нууц мэдээлэл өгөхийн тулд MoneyGram компанитай утсаар шууд холбоо барих боломжтой. Энэ шууд утсыг дараах нөхцөл байдалд ашиглавал зохино.</p> <ul style="list-style-type: none"> • Залилангийн сэдэлтэй байж болзошгүй хийгдэж буй бөгөөд яаралтай арга хэмжээ авах шаардлагатай үйлчлүүлэгчийн гүйлгээний тухай мэдэгдэх. • Агент эсвэл агентын ажилтан MoneyGram компанийн Олон улсын түнш байгууллага хууль тогтоомжийг хэрэгжүүлэх тухай бодлогын хууль тогтоомжийн болон ёсзүйн шаардлагыг зөрчсөн тухай мэдэгдэх. • MoneyGram компани эсвэл MoneyGram компанийн ажилтан Олон улсын түнш байгууллага хууль тогтоомжийг хэрэгжүүлэх тухай бодлогын хууль тогтоомжийн болон ёсзүйн шаардлагыг зөрчсөн тухай мэдэгдэх. • Агент эсвэл түүний ажилтан мөнгө угаах, үйлчлүүлэгчийг залилах эсвэл терроризмыг санхүүжүүлэх ажиллагаанд оролцсон хэмээн сэжиглэсэн тохиолдлыг мэдэгдэх. 	<p>Залиланг мэдэгдэх Утас Америкийн Нэгдсэн Улсад 1-800-866-8800</p> <p>Америкийн Нэгдсэн Улсаас өөр улсад http://corporate.moneygram.com/compliance</p> <p>Зөрчлийг мэдэгдэх Утас Америкийн Нэгдсэн Улс Англи эсвэл испани хэлээр ярих бол 1-800-866-8800</p> <p>Онлайн http://corporate.moneygram.com/compliance вебсайтад зочилж, онлайн маягыг бөглөнө үү.</p>
<p>Сэжигтэй эсвэл хачирхалтай байж болзошгүй үйл ажиллагааг мэдэгдэх Агент, түүний ажилтнууд сэжигтэй эсвэл хачирхалтай байж болзошгүй үйл ажиллагаа, үйлчлүүлэгчийг залилж болзошгүй тохиолдлыг шууд мэдэгдэх боломжтой.</p> <ul style="list-style-type: none"> • Сэжигтэй эсвэл хачирхалтай байж болзошгүй үйл ажиллагаа, үйлчлүүлэгчдийн хийхээр завдсан үйлдэлтэй холбоотой мэдээлэл өгөх. • Залилангийн сэдэлтэй байж болзошгүй бөгөөд хийгдэхээ больсон үйлчлүүлэгчийн гүйлгээний тухай мэдэгдэх. 	<p>Утас Америкийн Нэгдсэн Улс Англи эсвэл испани хэлээр ярих бол 1-800-866-8800</p> <p>Онлайн http://corporate.moneygram.com/compliance вебсайтад зочилж, онлайн маягыг бөглөнө үү.</p>

Холбоо барих шалтгаан	MoneyGram компанитай холбоо барих мэдээлэл
<p>Хууль сахиулах эсвэл зохицуулах байгууллагын хүсэлтийг хүлээн авч туслах</p> <p>Агент, түүний ажилтнууд хууль сахиулах эсвэл зохицуулах байгууллагын хүсэлт, лавлагаатай холбогдуулан MoneyGram компанитай холбоо барьж болно.</p>	<p>Эмэйл MGILEDirect@moneygram.com</p>
<p>Үйлчлүүлэгчийн нууцлал, мэдээллийг хамгаалах тухай хүсэлтийг хүлээн авч туслах</p> <p>Үйлчлүүлэгчийн хувийн мэдээллийн нууцлал эсвэл хамгаалалтыг задруулсан, бүрүүгаар ашигласан эсвэл эвдсэн эсвэл үүнд сэжиглэж буй аливаа тохиолдлыг мэдэгдэхийн тулд агент, түүний ажилтнууд MoneyGram компанитай нэн даруй холбоо барих ёстой.</p>	<p>Эмэйл PrivacyProgramOffice@moneygram.com</p>
<p>Агентад үзүүлэх ерөнхий туслалцаа</p> <p>Агент, түүний ажилтнууд дараах ерөнхий асуудлаар туслалцаа авахын тулд MoneyGram компанитай холбоо барьж болно.</p> <ul style="list-style-type: none"> • Үйлчлүүлэгчийн төлбөрийг буцаан олгох хүсэлт; • Технологи эсвэл тоног төхөөрөмжтэй холбоотой тусламж; • Систем эсвэл хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой сургалт зохион байгуулах хүсэлт; • Дээр заасан холбоо барих мэдээлэлд багтаагүй өөр бусад асуулт. 	<p>Утас Америкийн Нэгдсэн Улс Англи эсвэл испани хэлээр ярих бол 1-800-444-3010</p> <p>АГЕНТ НАДТАЙ ХОЛБОО БАРИХ ҮЙЛЧИЛГЭЭ <i>Веб</i> https://www.callmoneygram.com/moneygram</p> <p><i>Утас</i> +1 720 362 5024 (энэ дуудлага ямар ч төлбөргүй)</p> <p>POWERTRANSACT НАДТАЙ ХОЛБОО БАРИХ ҮЙЛЧИЛГЭЭ <i>Веб</i> https://www.callmoneygram.com/PwT</p> <p><i>Утас</i> +1 720 362 5025 (энэ дуудлага ямар ч төлбөргүй)</p> <p>Онлайн http://corporate.moneygram.com/compliance вебсайтад зочилж, онлайн маягыг бөглөнө үү.</p>